

ТАНИЛЦУУЛГА  
 “ӨСВӨР ҮЕ ХҮНС” ОНӨААТҮГ-Н 2022 ОНЫ КОНТРАКТ  
 БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ  
 ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ

2023.03.27

Улаанбаатар хот

Тус газар нь сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудыг эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан, баталгаатай хүнсний бараа бүтээгдэхүүнээр хангах зорилгоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 154 дүгээр тогтоолоор үүсгэн байгуулагдсан.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл:

- Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих үүднээс гол нэрийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрээс нь шууд нийлүүлэх
- Бусад нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг /импортын/ зах зээлийн боломжит үнээр нийлүүлэх
- Нийлүүлж буй бараа, бүтээгдэхүүнд гарал үүсэл, мэргэжлийн байгууллагын шинжилгээний дүгнэлт хийлгэж байх

*Удирдлага:* Нийслэлийн Засаг даргын 2016 оны Б/296 дугаар захирамжаар тус газрын захирлаар Ганбаатарын Мөнхзул томилогдон ажиллаж байна.

*Бүтэц орон тоо, дундаж цалин:* Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1093 тоот захирамжаар 28 ажиллагсадтай байхаар баталсны дагуу 2022 онд бүрэн орон тоогоор үйл ажиллагаа явуулсан. Ажиллагсдын дундаж цалин 2022 онд 1,032,000 төгрөг байна.

*Гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт:*

Тус газар нь аж ахуйн нэгжийн тайлан баланс гаргадаг бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайланд “Хаан Консалтинг Аудит” ХХК аудит хийж “Зөрчилгүй” санал дүгнэлт гарсан.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайлангаар хөрөнгө, эх үүсвэр дараах байдалтай байна.

/мянган төгрөг/

| <u>ХӨРӨНГӨ</u>                    | <u>2021.12.31</u> | <u>2022.12.31</u> | <u>ЭХ ҮҮСВЭР</u>        | <u>2021.12.31</u> | <u>2022.12.31</u> |
|-----------------------------------|-------------------|-------------------|-------------------------|-------------------|-------------------|
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 30,840.6          | 53,199.65         | Дансны өглөг            | 59,158.3          | 4,098.93          |
| Авлага                            | 6,306.0           | 1,882.78          | Татварын өр             | 98,378.4          | 32,298.00         |
| Бараа материал                    | 67,108.5          | 135,091.52        | Урт хугацаат өр төлбөр  |                   |                   |
| Урьдчилж төлсөн зардал            | 353.0             | 5,086.66          | <i>Өр төлбөрийн дүн</i> | <b>157,536.7</b>  | <b>36,396.93</b>  |
| <i>Эргэлтийн хөрөнгийн дүн</i>    | <b>104,608.2</b>  | <b>195,260.61</b> | Төрийн өмч              | 155,762.2         | 155,762.2         |

|                              |                  |                   |                                     |                  |                   |
|------------------------------|------------------|-------------------|-------------------------------------|------------------|-------------------|
| Үндсэн хөрөнгө               | 176,793.9        | 189,321.02        | Дахин үнэлгээний нэмэгдэл           | 21,679.55        | 21,679.55         |
|                              |                  |                   | Эздийн өмчийн бусад хэсэг           | 36,768.1         | 36,768.10         |
| Биет бус хөрөнгө             | 37,668.1         | 36,768.12         | Хуримтлагдсан ашиг                  | -52,676.3        | 170,742.97        |
| <i>Эргэлтийн бус хөрөнгө</i> | <b>214,462.0</b> | <b>226,089.14</b> | Эзэмшигчийн өмч өмч                 | <b>161,533.5</b> | <b>384,952.82</b> |
| Хөрөнгийн дүн                | <b>319,070.2</b> | <b>421,349.75</b> | Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн | <b>319,070.2</b> | <b>421,349.75</b> |

Тус үйлдвэрийн газар нь нийт 2022 оны жилийн эцэст нийт 421,3 сая төгрөгийн хөрөнгөтэй, үүнээс 195.26 сая төгрөгийн буюу 46.3 хувийг эргэлтийн хөрөнгө, 226.1 сая төгрөгийн буюу 53.7 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна. Эх үүсвэрийн 8.6 хувийг өр төлбөр, 91.4 хувийг өөрийн хөрөнгө эзлэж байна.

*Эргэлтийн бус хөрөнгийн өөрчлөлтийг нэр төрлөөр нь харуулбал:*

*/мянган төгрөг/*

|   | Төрөл                       | Бүртгэлийн үнэ<br>2021.12.31 | Нэмэгдсэн | Хасагдсан | Бүртгэлийн үнэ<br>2021.12.31 | Өөрчлөлт<br>/+, -/ |
|---|-----------------------------|------------------------------|-----------|-----------|------------------------------|--------------------|
| 1 | Барилга байгууламж          | 59,762.20                    | -         | -         | 59,762.20                    | -                  |
| 2 | Машин тоног төхөөрөмж       | 25,612.30                    | 7,621.80  | 280.0     | 32,954.1                     | 7,341.80           |
| 3 | Тээврийн хэрэгсэл           | 259,838.70                   | 53,181.8  | 51,180.0  | 261,840.5                    | 2,001.80           |
| 4 | Компьютер хэрэгсэл          | 31,171.00                    | 499.9     | 7,205.4   | 24,465.5                     | -6,705.5           |
| 5 | Тавилга эд хогшил           | 26,955.60                    | 3,580.0   | 2,055.0   | 28,480.6                     | 1,525.0            |
| 6 | Нийтийн эзэмшлийн хөрөнгө   | 15.60                        | -         | -         | 15.60                        | -                  |
|   | Үндсэн хөрөнгийн дүн        | 403,355.40                   | -         | -         | 407,518.5                    | 4,163.1            |
| 7 | Биет бус хөрөнгө            | 41,388.10                    | -         | 4,620.0   | 36,768.1                     | -4,620.0           |
|   | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 444,743.50                   | 64,883.5  | 65,340.4  | 444,286.6                    | -456.9             |

Тайлант онд эргэлтийн бус хөрөнгө 456.9 мянган төгрөгөөр хасагдаж, бүртгэлийн үнээр 444.3 сая төгрөг болсон байна. Тус үйлдвэрийн газар нь 2022 онд 64.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг холбогдох журам, төлөвлөгөөний дагуу өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр шийдвэрлэн авч, 65.3 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

*Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт: /Татвар, НДШ, Ногдол ашиг/*

*/мянган төгрөг/*

| № | Татвар            | 2021.12.31 | 2022.12.31 | Өөрчлөлт     |
|---|-------------------|------------|------------|--------------|
| 1 | ААНОАТ өр         | 54.3       | 15,834.1   | 15,779.8     |
| 2 | НӨАТ өр           | 98,184.1   | 16,342.0   | (81,842.1)   |
| 3 | Бусад татварын өр | 140.0      | 122.0      | (18.0)       |
| 4 | Дансны өглөг      | 2,145.0    | 1,375.0    | (770)        |
| 5 | Ногдол ашгийн өр  | 54,303.3   | 0          | (54,303.3)   |
| 6 | Бусад БХ өглөг    | 2,710.0    | 2,684.0    | (26.0)       |
|   | Нийт дүн          | 157,536.7  | 36,357.1   | (121,179.60) |

Нийт өр төлбөрийн хэмжээ 2021 оны жилийн эцэст 157.5 сая төгрөг байсан бол 2022 оны жилийн эцсийн байдлаар 36.4 сая төгрөг болж 76.9 хувиар бууруулан ажилласан байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 128 дугаар тогтоолоор тус газрын 2019 оны орлого үр дүнгийн цэвэр ашгаас 92,6 сая төгрөгийн ногдол ашиг төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлэснээс 2021 онд 9.3 сая төгрөгийг татварын байгууллагад, 29.0 сая төгрөгийн ногдол ашгийг төсөвт, 2022 онд ногдол ашгийн үлдэгдэл 54.3 сая төгрөгийг тус тус төсөвт төвлөрүүлсэн байна.

**Худалдан авалт, тендер хөрөнгө оруулалтын талаар:**

2022 оны зорилтоор 11.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлагдсан бөгөөд мөн нэмэлтээр 53.2 сая төгрөгийн ачааны автомашиныг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр шийдвэрлэн худалдан авахаар хүсэлт өгч нийт 64,8 сая төгрөгийн хөрөнгийг шинээр худалдан авчээ.

| № | Хөрөнгийн нэр төрөл          | Хэмжих нэгж | Төсөв /мян.төг/ |           | Гүйцэтгэл /мян.төг/ |           |
|---|------------------------------|-------------|-----------------|-----------|---------------------|-----------|
|   |                              |             | Тоо хэм-жээ     | Нийт үнэ  | Тоо хэм-жээ         | Нийт үнэ  |
| 1 | Хяналтын камер               | м,кв        | 1               | 5,000.0   | 1                   | 7,621.8   |
| 2 | Компьютер, дагалдах хэрэгсэл | ш           | 6               | 6,900.00  | 1                   | 499.90    |
| 3 | Тавилга эд хогшил            | ш           |                 |           | 6                   | 3,580.00  |
| 4 | Тээврийн хэрэгсэл            | ш           |                 |           | 1                   | 53,181.8  |
|   | Нийт дүн                     |             | 7               | 11,900.00 | 9                   | 64,883.50 |

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн дагуу худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор, төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хуудсанд тендерийн баримт бичиг болон урилгыг байршуулж шалгаруулалтыг зохион байгуулан ажилласан.

**Хийгдсэн гэрээ хэлцэл:**

Тус газрын захиралтай байгуулсан гэрээгээр 50,0 сая төгрөгөөс дээш гэрээ хэлцэлд зөвшөөрөл авахаар тусгагдсан ба тайлант онд дараах гэрээ хэлцлийг хийсэн байна. Үүнд:

| № | Барааны нэр төрөл   | Гэрээний дугаар       | Гэрээ байгуулсан огноо | Байгууллагын нэр     | Гэрээн ий төрөл | /мянган төгрөг/ |              |
|---|---------------------|-----------------------|------------------------|----------------------|-----------------|-----------------|--------------|
|   |                     |                       |                        |                      |                 | Төсөвт өртөг    | Гэрээний дүн |
| 1 | Хонины мах          | ӨҮХОНӨААТҮГ/202201001 | 2022.03.14             | Хулагу холдинг ХХК   | НТШ             | 1,221,436.8     | 1,145,097.0  |
| 2 | Үхрийн мах          | ӨҮХОНӨААТҮГ/202201001 | 2022.03.14             | Хулагу холдинг ХХК   | НТШ             | 2,636,368.4     | 2,487,140.0  |
| 3 | Төмс, хүнсний ногоо | ӨҮХОНӨААТҮГ/202201001 | 2022.03.25             | Эрдэнэ энх трейд ХХК | НТШ             | 448,920.5       | 351,532.7    |
| 4 | Гурил               | ӨҮХОНӨААТҮГ/202201001 | 2020.01.00<br>3        | Улаанбаатар гурил,   | ГШБА            | 143,736.4       | 143,736.4    |

|    |                       |                           |            |                                    |      |             |             |
|----|-----------------------|---------------------------|------------|------------------------------------|------|-------------|-------------|
|    |                       |                           |            | Милл Хаус ХХК                      |      |             |             |
| 5  | Элсэн чихэр           | ӨҮХОНӨААТҮГ/<br>202201001 | 2020.04.24 | Грийн ХХК                          | ГШБА | 165,448.5   | 165,448.5   |
| 6  | Байгалийн жимс        | ӨҮХОНӨААТҮГ/<br>202201001 | 2022.07.06 | Арвин мөнх дэлгэрэх ХХК            | НТШ  | 356,812.0   | 356,307.5   |
| 7  | Цагаан будаа          | ӨҮХОНӨААТҮГ/<br>202201001 | 2020.04.24 | Грийн ХХК                          | ГШБА | 248,654.0   | 248,654.0   |
| 8  | Будааны төрлүүд       | ӨҮХОНӨААТҮГ/<br>202201001 | 2020.04.24 | Грийн ХХК                          | ГШБА | 318,845.8   | 318,845.8   |
| 9  | Цагаан идээ           | ӨҮХОНӨААТҮГ/<br>202201001 | 2020.09.01 | Мөнх Дээж ХХК                      | ГШБА | 186,358.0   | 186,358.0   |
| 10 | Гадаад жигнэмэг       | ӨҮХОНӨААТҮГ/<br>202201001 | 2020.10.06 | Бат трейд си ХХК                   | ГШБА | 118,602.0   | 118,602.0   |
| 11 | Нарийн ногоо          | ӨҮХОНӨААТҮГ/<br>202201001 | 2022.03.25 | Эрдэнэ энх трейд ХХК               | НТШ  | 210,379.5   | 210,304.5   |
| 12 | Компотны материал     | ӨҮХОНӨААТҮГ/<br>202201001 | 2022.03.25 | Супер ирээдүй ХХК, Зазига ХХК      | ГШБА | 202.150.0   | 202.150.0   |
| 13 | Ургамлын тос          | ӨҮХОНӨААТҮГ/<br>202201001 | 2020.02.21 | Фүүд сервис солюш ХХК, Боса импекс | ГШБА | 109,822.1   | 109,822.1   |
| 14 | Гадаад гоймон         | ӨҮХОНӨААТҮГ/<br>202201001 | 2020.04.24 | Грийн ХХК                          | ГШБА | 77,091.3    | 77,091.3    |
| 15 | Дотоод жигнэмэг       | ӨҮХОНӨААТҮГ/<br>202201001 |            | Том бат ХХК                        | ГШБА | 75,595.3    | 75,595.3    |
| 16 | Түгээлтийн авто машин | ӨҮХОНӨААТҮГ/<br>202209002 | 2022.11.09 | Би Ай Мэжор Консалтинг ХХК         | ХА   | 70,000.0    | 58,500.0    |
|    | Нийт дүн              |                           |            |                                    |      | 6,388,070.0 | 6,053,035.1 |

**Удирдах зөвлөл болон НӨХГ-ын шийдвэрийн хэрэгжилт :**

Тус газар нь удирдах зөвлөлгүйгээр үйл ажиллагаа явуулдаг. "Нийслэлийн өмчийн харилцааны газар"-аас өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гарган өгч, шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж ирсэн. Нийслэлийн өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг хугацаанд нь тайлагнасан.

**Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдал :**

Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг шинээр байгуулж хагас, бүтэн жилийн эд хөрөнгө, аж ахуйн тооллого хийж хүн нэг бүрээр карт хөтөлж, эд хөрөнгө тавилга тоног төхөөрөмжийг хариуцуулан бүртгэлжүүлсэн. 2022 онд улсын хэмжээнд зохион байгуулсан улсын өмчийн тооллогод бүх эд хөрөнгөө хамруулан тоолж холбогдох дээд байгууллагад тайлан мэдээг хүргүүлэн ажилласан. 2022 оны жилийн эцсийн тооллогоор үндсэн хөрөнгийн үлдэгдэл 226,1 сая төгрөг, бараа материалын үлдэгдэл 135,1 сая төгрөг байна.

**Эдийн засгийн үр дүнг 2022 онд дээшлүүлэх зорилтот түвшний биелэлт**

/мянган төгрөг/

| Д/д   | Үзүүлэлт                        | 2021 оны гүйцэтгэл  | 2022 оны          |                   | Биелэлт           |               |
|-------|---------------------------------|---------------------|-------------------|-------------------|-------------------|---------------|
|       |                                 |                     | Зорилт            | Гүйцэтгэл         | Зөрүү             | Хувь          |
| 1.1   | Борлуулалтын орлого             | 2,209,397.12        | 9,528,919.5       | 7,700,404.34      | (1,828,515.16)    | 80.81         |
| 1.2   | Бусад орлого                    | 1,400.13            | 550.0             | 1,621.19          | 1,071.19          | 294.76        |
| 1.3   | Хүүгийн орлого                  | 2,720.12            | 0.00              | 0.00              |                   |               |
| 1     | Нийт орлого                     | 2,213,517.37        | 9,529,469.5       | 7,702,025.53      | 1,827,443.97      | 80.82         |
| 2.1   | ББӨ                             | 1,961,790.82        | 8,662,654.13      | 6,843,444.67      | 1,819,209.46      | 80.00         |
| 2.2   | Цалин                           | 273,656.30          | 489,783.66        | 345,485.0         | 144,298.66        | 70.53         |
| 2.3   | Хоол унааны зардал              | 19,124.00           | 47,127.60         | 39,496.60         | 7,631.00          | 83.80         |
| 2.4   | Нийгмийн даатгалын шимтгэл      | 36,811.60           | 67,113.91         | 47,971.40         | 19,142.51         | 71.47         |
| 2.5   | Шуудан холбоо                   | 4,800.50            | 5,749.60          | 3,995.59          | 1,754.01          | 69.49         |
| 2.6   | Цахилгаан                       | 13,865.00           | 15,240.00         | 10,587.98         | 4,652.02          | 69.47         |
| 2.7   | Шатахуун                        | 14,720.00           | 19,822.00         | 21,949.07         | (2,127.07)        | 110.73        |
| 2.8   | Бичиг хэрэг                     | 2,380.00            | 5,040.0           | 4,234.56          | 805.44            | 84.01         |
| 2.9   | Хөдөлмөр хамгаалал              | 2,912.80            | 9,980.0           | 5,100.91          | 4,879.09          | 51.11         |
| 2.10. | Ашиглалтын зардал               | 3,200.00            | 5,152.0           | 5,329.29          | (177.29)          | 103.44        |
| 2.12  | Хангамжийн зардал               | 3,300.00            | 9,240.0           | 8,454.98          | (785.02)          | 91.50         |
| 2.13  | Засварын зардал                 | 5,925.00            | 17,000.0          | 13,432.93         | 3,567.07          | 79.01         |
|       | Түрээсийн зардал                | 0                   | 24,500.0          | 12,413.33         | 12,086.67         | 50.66         |
| 2.14  | Бусад зардал                    | 12,328.27           | 14,625.0          | 12,665.20         | 1,959.80          | 86.60         |
| 2.2   | Элэгдлийн зардал                | 41,575.43           | 40,653.0          | 40,291.40         | 361.60            | 99.11         |
| 2.2   | Сэлбэг хэрэгсэл                 | 9,931.90            | 8,750.00          | 8,621.27          | 128.73            | 98.52         |
| 2.2   | Сургалтын зардал                | 675.00              | 2,420.0           | 400.0             | 2,020.00          | 16.52         |
| 2.2   | Албан томилот                   | 0.0                 | 15,000.0          |                   | 15,000.0          | 0             |
| 2.2   | Татвар, даатгал                 | 1,652.18            | 1,908.00          | 1,739.32          | 168.68            | 91.16         |
|       | Үйл ажиллагааны зардал          | <b>446,857.98</b>   | <b>799,105.17</b> | <b>582,168.83</b> | <b>216,936.34</b> | <b>72.85</b>  |
| 2.2   | Үйл ажиллагааны бус зардал      | 12,773.20           | 26,195.00         | 25,351.57         | 843.43            | 96.77         |
| 2     | Нийт зардал                     | 2,421,422.00        | 9,488,244.30      | 7,450,965.07      | 2,037,279.23      | 78.52         |
| 3     | Татвар төлөхийн өмнөх ашиг      | (207,904.63)        | 41,515.23         | 251,060.46        | 209,545.23        | 604.74        |
| 4     | Орлогын татварын зардал         | 412.00              | 4,151.52          | 27,641.20         | 23,489.68         | 665.80        |
| 5     | Цэвэр ашиг                      | <b>(208,316.63)</b> | <b>34,744.21</b>  | <b>223,419.26</b> | <b>188,675.05</b> | <b>643.04</b> |
| 6     | Орлогын 1 төгрөгт ногдох зардал | 1.09                | 1.0               | 0.97              | 0                 | 0             |
| 7     | Нийт авлага                     | 8,511.30            | 5,000.0           | 1,880.78          | 3,119.22          | 37.61         |
| 8     | Нийт өглөг                      | 113,123.60          | 50,000.0          | 36,357.1          | 13,642.90         | 72.71         |
| 9     | Хөрөнгө оруулалт                | 4,819.90            | 11,900.0          | 64,883.50         | (52,983.50)       | 545.23        |

Тайлант онд нийт 9,529.5 сая төгрөгийн орлого олж, 9,488.2 сая төгрөгийн зардал гарган, 34.7 сая төгрөгийн ашигтай ажиллахаар зорилтот түвшин батлагдсан. Гүйцэтгэлээр нийт 7,702.1 сая төгрөгийн орлого олж, 7,450.9 сая төгрөгийн зардал гарган, 223,4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

#### *Орлогын талаар:*

Тус газар нь 2022 оны зорилтот түвшингээр 9,529.5 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажиллаж, гүйцэтгэлээр 7,702.1 сая төгрөгийн орлого олж, төлөвлөгөө 1,827.4 сая төгрөгөөр тасарч, төлөвлөгөөний биелэлт 80.8 хувьтай байна. Энэ нь манай байгууллага ХУД, БЗД-ийн бүх ЕБСургуулиудад хүнсний бараа бүтээгдэхүүн нийлүүлэхээр төлөвлөж байсан бөгөөд 2022 онд зөвхөн 14 сургуультай гэрээ хийж хамтран ажилласантай холбоотойгоор орлогын төлөвлөгөө биелээгүй байна гэж дүгнэж байна.

#### *Зардлын талаар:*

2022 оны зорилтот түвшингээр нийт зардлыг 9,488.2 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 7,450.9 сая төгрөгийн зардал гарган ажилласан байна. Зардал 2,037.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн мэт харагдаж байгаа боловч энэ нь орлогын төлөвлөгөөний тасалдалтай шууд хамааралтай байна.

Нийт зардлын 91.85 хувийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг 7.81 хувийг ерөнхий удирдлагын зардал, 0,34 хувийг үйл ажиллагааны бус зардал эзлэж байгаа бөгөөд ерөнхий удирдлагын зардлын 66.12 хувийг цалин болон хүний нөөцтэй холбоотой бусад зардал, 6.9 хувийг элэгдлийн зардал, 8.24 хувийг НДШ-ийн зардал 3.8 хувийг шатахууны зардал, 2.3 хувийг засвар үйлчилгээний зардал тус тус эзэлж байна.

2022 оны зардлын гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийг нэр төрлөөр нь авч үзвэл:

*2022 онд үйл ажиллагааны зардлыг нийт 216.9 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.*

*Гол хэмнэгдсэн зардлуудын хувьд:*

- Цалингийн зардал болон хоол унааны зардал 151.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Энэ нь 20 хувийн цалингийн нэмэгдлийг оны эхнээс олгохоор төлөвлөсөн ч мөнгө хөрөнгийн нөөцгүй бусад чухал зардлуудыг санхүүжүүлэх шаарлагатай байсны улмаас 2022 оны 9 дүгээр сараас нэмэгдүүлэн олгосноос шалтгаалж байна.
- Цалингийн хэмнэлттэй холбоотой НДШ-н зардлыг 19.1 сая төгрөгөөр хэмнэн ажилласан байна.
- Эхний хагас жил байгаа нөөцөө ашиглан хөдөлмөр хамгааллын зардлыг 4.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.
- Түрээсийн зардал 12.1 сая төгрөгөөр хэмнэж ажилласан. Түрээсийн байрыг 2022 оны 2-р хагас жилээс гэрээ хийн ажиглаж эхэлсэн. Эхний хагас жилийн түрээсийг хэмнэсэн байна.
- Цахилгааны зардал 4.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь зарцуулалтад хяналт тавьж ажилласантай холбоотой.
- Хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг ханган 15.0 сая төгрөгийн албан томилолтын зардлыг тус тус хэмнэн ажилласан байна.

#### *Цэвэр ашиг, алдагдлын талаар:*

2022 онд 34,7 сая төгрөгийн ашигтай ажиллахаар зорилт тавин ажиллаж гүйцэтгэлээр хэмнэлт гарган ажилласны улмаас 223.4 сая төгрөгийн ашигтай ажиллаж төлөвлөгөөгөө давуулан биелүүлжээ.

*Авлагын талаар:*

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 6,3 сая төгрөгийн авлагатай байсан бол 2022 оны жилийн эцсийн байдлаар 1.8 сая төгрөгийн дансны авлагын үлдэгдэлтэй гарч авлага 4.42 сая төгрөгөөр буурсан байна. Энэ авлага нь тайлант хугацаанд барагдах хэвийн авлага болно.

*Өглөгийн талаар:*

(мянган төгрөгөөр)

| № | Татвар            | 2021.12.31 | 2022.12.31 | Өөрчлөлт     |
|---|-------------------|------------|------------|--------------|
| 1 | ААНОАТ өр         | 54.3       | 15,834.1   | 15,779.8     |
| 2 | НӨАТ өр           | 98,184.1   | 16,342.0   | (81,842.1)   |
| 3 | Бусад татварын өр | 140.0      | 122.0      | (18.0)       |
| 4 | Дансны өглөг      | 2,145.0    | 1,375.0    | (770)        |
| 5 | Ногдол ашгийн өр  | 54,303.3   | 0          | (54,303.3)   |
| 6 | Бусад БХ өглөг    | 2,710.0    | 2,684.0    | (26.0)       |
|   | Нийт дүн          | 157,536.7  | 36,357.1   | (121,179.60) |

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 157.5 сая төгрөгийн өглөгтэй байсан бол 2022 оны жилийн эцсийн байдлаар 36,3 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй болж өглөг 121,2 сая төгрөгөөр буурсан байна.

**Санхүүгийн тайлангийн шинжилгээ:**

| Үзүүлэлт                                  | 2021.12.31 | 2022.12.31 | Зөрүү    |
|---|------------|------------|----------|
| 1. Төлбөрийн чадварын үзүүлэлт            |            |            |          |
| Эргэлтийн харьцаа ЭХ/БХӨТ                 | 2.2        | 5.36       | 3.2      |
| Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа        | 1.05       | 1.46       | 0.41     |
| Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа           | 1.1        | 1.5        | 0.4      |
| 2. Ашигт ажиллагааны үзүүлэлт             |            |            |          |
| Борлуулалтын өгөөж                        | -0.09      | 0.029      | 0.061    |
| Хөрөнгийн өгөөж                           | -0.49      | 0.53       | 0.04     |
| Цэвэр активын өгөөж                       | -0.67      | 0.58       | 0.09     |
| 3. Өрийн хөшүүргийн үзүүлэлт              |            |            |          |
| Өрийн харьцаа                             | 0.26       | 0.086      | 0.17     |
| Өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа        | 0.36       | 0.09       | 0.26     |
| 4. Нийт хөрөнгийн ашиглалтын үзүүлэлт     |            |            |          |
| Бараа материалын эргэц                    | 54.89      | 50.65      | 4.23     |
| Дансны авлагын эргэц                      | 259.58     | 4089.91    | 3,830.33 |
| Авлага цуглуулах хугацаа                  | 1.41       | 0.09       | 1.32     |
| 5. Санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлт |            |            |          |
| Бие даах чадварын коэффициент             | 0.73       | 0.91       | 0.18     |
| Санхүүгийн хамаарлын коэффициент          | 1.36       | 1.09       | 0.26     |

|                                    |      |      |      |
|------------------------------------|------|------|------|
| Борлуултын 1 төгрөгт ногдох зардал | 1.07 | 0.96 | 0.10 |
|------------------------------------|------|------|------|

*Нэг. Төлбөрийн чадварын шинжилгээ*

А. Эргэлтийн харьцаа = Эргэлтийн хөрөнгө / БХӨТ

/Зохистой харьцаа 2.0-с дээш/

Энэ үзүүлэлт нь эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрөө тайлант хугацаанд хэдэн удаа төлж барагдуулах чадвартайг харуулна. Энэ харьцаа нь 2.0-оос дээш байвал зохистой гэж үздэг бөгөөд 2021 оны жилийн эцсээр энэ үзүүлэлт 2.2 байсан бол 2022 онд 5.36 болж өссөн байна. Өөрөөр хэлбэл 2021 онд өр төлбөрийн хэмжээ их байгаатай холбоотой үзүүлэлт өндөр байсан бөгөөд 2022 оны хувьд өр төлбөрийн хэмжээ өмнөх жилээс буурсан тул өсөлттэй гарсан байна. Өөрөөр хэлбэл эргэлтийн хөрөнгөөр өглөгөө 5.3 удаа төлж барагдуулахуйц төлбөрийн чадвартай байгааг харуулж байгаа юм.

Б.Хөрвөх хөрөнгийн харьцаа = (Мөнгөн хөрөнгө + ТБҮЦ)/ БХӨТ

/Зохистой харьцаа 0.2-с дээш/

Энэхүү үзүүлэлт нь төлбөрийн чадварын өнөөгийн боломжийг илэрхийлсэн шалгуур бөгөөд БХӨТ-ийг мөнгөн хөрөнгөөр хэдэн удаа барагдуулж чадахыг харуулдаг. 2022 онд энэ харьцаа 1.46 болж өссөн байна.

В. Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа = (Мөнгөн хөрөнгө + Авлага) / БХӨТ

/Зохистой харьцаа 0,8-1,0/

Энэ харьцаа нь эргэлтийн хөрөнгийн тодорхой хэсэгээр төлбөр барагдуулах ойрын боломжийг харуулдаг. Төлбөрийн хэрэгсэл болж ашиглагдах бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээг харуулдаг гол шалгуур. Дээрхээс харахад түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа 2021 онд төлбөр барагдуулах ойрын боломж доогуур үзүүлэлттэй байсан бол энэ оны хувьд 1.5 болж өсжээ.

*Хоёр. Ашигт ажиллагааны шинжилгээ*

А. Борлуулалтын өгөөж = Цэвэр ашиг / Борлуулалтын орлого

Б.Хөрөнгийн өгөөж = Цэвэр ашиг / Нийт хөрөнгө

В. Капиталын өгөөж = Цэвэр ашиг / Өөрийн капитал

Ашигт ажиллагааны шинжилгээ нь тайлант хугацаанд байгууллага хэр ашигтай ажилласныг харуулдаг. 2021 онд Борлуулалтын өгөөж, хөрөнгийн өгөөж маш доогуур үзүүлэлттэй байсан нь дээрх шинжилгээнээс харагдаж байна. Харин 2022 онд мөн ашигт ажиллагааны үзүүлэлтүүд өссөн байна.

*Гурав. Өрийн хөшүүргийн үзүүлэлт*

А. Өрийн харьцаа = Өр төлбөрийн нийт дүн / Өр төлбөр ба ЭӨ-ийн дүн

Б. Өр төлбөр ба ЭӨ-ийн харьцаа = Өр төлбөрийн нийт дүн / ЭӨ-ийн дүн

2021 онд Өрийн харьцаа маш бага буюу нийт эх үүсвэрийн 0.26 хувийг өр төлбөр эзэлж байсан бол энэ онд 0,08 болсон байгаа нь өр төлбөрийн бууралттай шууд холбоотой юм.

*Дөрөв. Нийт хөрөнгийн ашиглалтын үзүүлэлт*

А. Бараа материалын эргэц = ББӨ/ Бараа материал/Удаа/

Б. Дансны авлагын эргэц = Борлуулалтын орлого / Авлага/Удаа/

В. Авлага цуглуулах хугацаа = 365 / Авлагын эргэц

*Тав. Санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлт*



А. Бие даах чадварын коэффициент = ЭӨ / Нийт өр төлбөр эздийн өмчийн дүн  
/Зохистой харьцаа 0,5-1,0/

Бие даах чадварын коэффициент нь 2022 онд 0.91 байгаа нь зохистой харьцаандаа буюу гадаад эс үүсвэрээс хараат бусаар гагцхүү өөрийн санхүүжилтээр бие даан үйл ажиллагаа явуулах чадвар өндөр байна: Энэ үзүүлэлт 2021 оныхоос 0,18 функтээр өсжээ.

Б. Санхүүгийн хамаарлын коэффициент = Нийт өр төлбөр ба ЭӨ дүн/ ЭӨ /Зохистой харьцаа 1,0-3,0/. Санхүүгийн хамаарлын коэффициент нь 1.09 байгаа нь зохистой харьцааг хангаж байна.

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

“ӨСВӨР ҮЕ ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Ш.ОТГОНЖАРГАЛ